

ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2024.05.27

Өвт

Бат-Өлзий сумын Соёлын төвд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 11 цаг 30 минутад “Хог хаягдлын хураамжийн 2022, 2023 оны хэрэгжилт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх төсвийн хяналт, хогны менежмент”-д Нийтийн сонсголын үйл ажиллагаа эхлэв.

Төсвийн хяналтын нийтийн сонсголын зохион байгуулагчаар иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга Ц.Чинбаяр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сонсгол даргалагчаар ИТХ-ын төлөөлөгч Д.Цэрэнтогтох, дуудагдаж ирсэн албан тушаалтнаар ТҮК-ийн дарга Г.Бямбагарав, ТҮК-ийн нягтлан бодогч Б.Сангицэрэн, Засаг даргын орлогч Н.Орхонтуул, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Янжиндулам нар, оролцогчоор Д.Мөнхнасан, А.Долгор-Өлзий, Д.Амирдаабазар, С.Дашдэмбэрэл, О.Батсүрэн, Д.Гантөмөр нар шинжээчээр Э.Дашдулам, ажиглагчаар 40 иргэн, албан хаагч оролцлоо. Сонсголын үйл ажиллагааг нээж ИТХ-ын дарга Ц.Чинбаяр үг хэллээ.

ХЭЛЭЛЦСЭН нь:

Ц.Чинбаяр (ИТХ-ын дарга): Нийтийн сонсголын зорилго нь иргэдийг мэдээллээр хангаж, оролцоог нэмэгдүүлэх, 2017 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангахад оршино. Энэ жил 6 дах удаагаа зохион байгуулж байна. Сонсгол нь хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулдаг. Сонголоор ямар нэгэн шийдвэр гарахгүй.

Энэ удаа “Хог хаягдлын хураамжийн 2022, 2023 оны хэрэгжилт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх төсвийн хяналт, хогны менежмент”-д сонсголыг зохион байгуулж байна.

Д.Цэрэнтогтох (Сонсгол даргалагч): Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Сумын ИТХ-ын Нийтийн сонсголын дэгийг уншиж танилцуулав. (Дэгийг хавсаргав)

Нийтийн сонсголд хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан хаагч, сонсголд оролцогчид үг хэлэхдээ 5 минут, амаар болон бичгээр асуулт асууж болно. Асуулт 4 минут, дараагийн удаа 1 минут, үг хэлэхдээ 3 минут байна.

Ажиглагчид үг хэлж, асуулт асуухгүй. Ингээд үйл ажиллагаандаа орёе. Сонсголд дуудагдсан оролцогч Тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын нягтлан бодогч Б.Сангицэрэн 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийнэ. Мэдээлэл 15 минутаас хэтрэхгүй байна.

Б.Сангицэрэн (Дуудагдсан албан тушаалтан, Нягтлан бодогч): Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сумын Тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022, 2023 оны төсвийн зарцуулалтын талаар мэдээлэл хүргэе. (танилцуулгыг хавсаргав)

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): Сангицэрэнд баярлалаа. Одоо Сонсголд дуудагдсан оролцогч Тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Г.Бямбагарав мэдээлэл хийнэ.

Г.Бямбагарав (Дуудагдсан албан тушаалтан, дарга): Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сумын Тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022, 2023 оны үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэе. (танилцуулгыг хавсаргав)

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): Бямбагаравдаа баярлалаа. Оролцогчид 5 минутад багтааж үг хэлнэ. Мэдээлэлтэй холбоотой асуулт, санал байна уу.

Д.Мөнхнасан(оролцогч): Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе ажилчдын цалин хаанаас санхүүждэг цалин хэд вэ?

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): Оролцогч Мөнхнасангийн асуултад нягтлан бодогч Б.Сангицэрэн мэдээлэл өгнө үү.

Б.Сангицэрэн (Дуудагдсан албан тушаалтан, Нягтлан бодогч): Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр Орон нутгийн төсвөөс цалинждаг.

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): За баярлалаа. Дараагийн оролцогч Амирдаабазарыг урьж байна.

Д.Амирдаабазар (оролцогч): Манай сум ковш машинтай болсон байсан тэр нь ЗДТГ-ын хашаанд байдаг энэ Тамгын газарт байх нь зөв юм уу? Энэ машинаа ямар төсвөөр авсан бэ? Энэ ковшоо хогны цэг дээрээ ажиллуулж болдоггүй юм уу? Суманд явж байгаа хогны машинууд нь эвдрээ л одоо нэг муу машин явдаг ч юм уу үгүй ч юм уу. Цутгалангийн жуулчны баазуудын хогыг хогийн цэг дотроо орж асгуулдаг баймаар байна. Тэгэхгүй хойно нь ирж буулгачхаад яваад өгөх юм.

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): Оролцогч Амирдаабазарын асуултад Бямбагарав мэдээлэл өгнө үү.

Г.Бямбагарав (Дуудагдсан албан тушаалтан, дарга): Хогны 2 машин 3 жил 6 сар ашиглагдаж байгаа нэг нь эвдрээд урсгал засвар байхгүй зөвлөлөөрөө яриад 2 машинаа сэлбээд нэг машин болгоод ажилд гараад явж байгаа. Анх ирэхдээ 20 см хүрэхтэй үгүйтэй тэвштэй ирсэн манай жолооч нар өөрсдөө өндөрлөгөө хийсэн. Ковш машины хувьд ТҮК дээр өмчилж аваагүй 2023 онд ирсэн сайн ажиллуулж чаддаг хүн эзэмшихгүй эвдэрч хэмхрэх юм бол хэн хариуцлага хүлээх үү энэ чинь бас өөрөө нэлээн үнэтэй тийм учраас манайх ТҮК дээрээ хүлээж авахгүй Тамгын газрын өмчид өгч хог дээр ажиллуулах үедээ ажиллуулаад байя гэдэг саналаа хэлээд ТҮК дээрээ

аваагүй. Сумаас мөнгө төсөв дээр суутгаж аваагүй өрөнд авсан энэ талаарх тодорхой мэдээллийг орлогч дарга өгөх байх.

Д.Гантөмөр (оролцогч): Урьд нь авсан хогны машин, ковш яахаараа ингээд ашиглаж болдоггүй юм Сонсмал, Ковш 100 саяаар авлаа гээл байсан 1,2 жил болсон уу үгүй үү дахиа л хогны машин солих юм анх эхлээл нэг портер дараа нь нэг хятад тэрэг авч байсан тэрийгээ 1,2 жил ажиллууллаа л өөрсдөө хувьдаа авчдаг. Дараа нь 100 саяаар Сонсмал, Ковш авсан бас л 1,2 жил явсан эзэмшиж хариуцсан хүн байхгүй сүүлдээ өөрсдийнхөө хувийн машиныг сэлбэл дахиа л хогны машин авдаг. Тэрний оронд нэг гайгүй зориулалтын хогны машин аваад найдвартай чадварлаг жолоочтой болох хэрэгтэй.

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): Засаг даргын орлогч Н.Орхонтуул ковштой холбоотой нэмэлт мэдээлэл өгнө үү.

Н.Орхонтуул (Дуудагдсан албан тушаалтан, Засаг даргын орлогч): Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Оролцогчдын зүгээс тодорхой асуултыг асуугаад холбогдох мэргэжилтнүүд маань хариулаад явж байна. Ер нь бол хогтой холбоотой асуудлаар иргэдээс тухай онд болон дараа онд хийгдэх ажлуудын саналыг авдаг хогны 2 жижиг машин ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд авч байсан. Ковшны хувьд баруун сөдтийн уул уурхай нөхөн сэргийлэлт хийх ёстой байсан компани хийгээгүй нь шүүхийн шийдвэрээр батлагдаж 176 сая төгрөгийн нөхөн төлбөр гарж энэ тухайн компанийн эзэд Улаанбаатар хот руу шилжсэний улмаас шүүхийн шийдвэр дагаж шилжих байсан тулд манайх энэ ковш машиныг уул уурхайн нөхөн төлөлт хийгээгүй төлбөрт авч үлдсэн. Миний санаж байхаар манай суманд 2012 онд ковш машин авч байсан санагдаж байна. Засаг даргын Тамгын газар дээр өмчлөгдөөд явдаг тухайн техникүүдийг хариуцах эзэнтэй болгож гэрээ байгуулж явж байсан. ТҮК-ийн ажиллагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр орон нутгийн төсвөөс санхүүждэг. Төвлөрсөн хогийн цэгийг өөрчлөх байршлыг судлах, иргэдээс санал авах ажлын хэсэг 2023 онд байгуулагдан ажилласан. Манай сумын хувьд 70, 80 хувь нь тусгай хамгаалалттай газар орчны бүс нь 20, 30 хувь болчихоод байгаа хогийн төвлөрсөн цэгийн байршлыг энд байршуулъя гэсэн тодорхой цэгийг сонгоход хэцүү байгаад байна. Цаашид бол хогны цэгийн асуудлыг шийдэх асуудал бол зам тавих зорилгоор үүсээд байгаа карьеруудыг ашиглах сүүлийн ИТХ-ын хурлаар энэ асуудал яригдсан.

О.Батсүрэн (оролцогч): Хогийн цэгийн хувьд урьд нь доошлуулцан байсанг нь ИТХ-ын хурлаар дээшээ буцаагаад толгой дээр авчраад тавьцан.

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): Батсүрэн эгчийн асуултад тухай үед Хурлын дарга байсан хүний хувьд мэдээлэл өгье гэж бодож байна. Хогийн цэгийн ИТХ-ын төлөөлөгчид дур мэдээд энд буцаагаад байгуулсан зүйл бол байхгүй нөхцөл байдлын үнэлгээ дээр хогийн цэг хуучин цэг дээрээ багтахаа байсан. 2006 онд одоогийн хогийн цэгийг ашигладаг байсан. Манай сумын хувьд тусгай хамгаалалттай газар 70, 80 хувийг эзэлдэг болохоор хогийн цэг байршуулах газар үнэхээр хэцүү. ИТХ-ын хэсэг төлөөлөгчид санаачлаад ТҮК-ийг байгуулаад тухайн үеийн Засаг дарга

М.Жамъяншарав эдийн засаг төсвийн гаргалгааг гаргаж өгөөд ТҮК-ийн үйл ажиллагаа жигдэрсэн тодорхой үр дүн гарсан гэж үзэж байна. Та хэдийнхээ санал шүүмжийг хүлээн авна.

Б.Янжиндулам (Дуудагдсан албан тушаалтан, БОХУБ): Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бохирдсон газар хогийн цэгээ үүсгэх ёстой тэрнээс бол эрүүл газар хогийн цэг үүсгэх боломжгүй тэр утгаараа хуучин хогийн цэг хийж байсан газар үүссэн байгаа. 2024 он гарснаар иргэдээс хогийн тариф шинэчлэх санал авч ИТХ-ын 20 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж Хууль зүйн яам руу хүргүүлсэн хариу нь гараагүй байна. Шинэчлэх болсон шалтгаан нь ТҮК-ийн үйл ажиллагааг сайжруулах, нийгмийн баталгааг сайжруулах зорилготой. Энэ онд ТҮК-ийн үйл ажиллагаа дээр самрын орлого гайгүй байсан болохоор 180 сая төгрөг батлуулсан 120 саяаар нь үртэсний асуудлаа шийдвэрлэх, 20 саяаар нь хөг хаягдлын менежментийн төлөвлөгөө хийлгэх.

Д.Цэрэнтогтох (Сонсгол даргалагч): За баярлалаа. Дараагийн оролцогч Долгор-Өлзий асуултаа асуугаарай.

А.Долгор-Өлзий (оролцогч): Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний хувьд Бямбагараваас 03 дугаар сарын 19-ны өдөр ТҮК-ийн ажлыг хүлээж авсан. Ковшийг эхлээд ажилд оруулах саналтай нутгийн хүүд учирлаад хямдхан сэлбэг авч тавиад одоо ажиллаж байгаа Сонсмолыг мөн адил засварласан одоо ажиллаж байгаа. Мөнхөө гэдэг чадварлаг жолооч ажиллаж байгаа. Хог пресслэж байсан газрын торон хашаа, төмөр шон байсан зүүн талын шон бүгд алдагдсан байна гэж хэл ирсэн одоо тэрийг яах вэ? Сахиул бол байнга хойно ажиллаж байгаа.

Г.Бямбагарав (Дуудагдсан албан тушаалтан, дарга): Хуучин хогийн цэгийн торон хашааг авч хоёрдогч түүхий эд авдаг торон хашаа болгосон нэг шөнө нэлээн хэдэн шон алдсан цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн. Сүүлдээ бүүр иргэдээ айлгах зорилгоор ажилладаггүй камер хүртэл тавьж ажиллаж үзсэн.

Д.Цэрэнтогтох(Сонсгол даргалагч): За баярлалаа. Оролцогч Д.Амирдаабазар саналаа хэлнэ үү гэж урьж байна.

Санал дүгнэлт:

Д.Амирдаабазар (оролцогч): Хогны машинаа сайжруулмаар байна. Энэ зургийг харахад бол хүүхдийн тоглоом шиг л жижигхэн юм байхын тэрэнд нь айлын хог бүрэн багтдаггүй. Хогны зориулалтын өөрөө хогоо буулгадаг тэвш нь дээшээ доошоо болдог тийм арай гайгүй машинтай болох хэрэгтэй байх. Айлууд бас хогоо ангилдаг баймаар байна.

Д.Цэрэнтогтох (Сонсгол даргалагч): За баярлалаа. Оролцогч Батсүрэнг урьж байна.

О.Батсүрэн (оролцогч): Ганцхан хогны машин биш ер нь албаны машиныг барьж байгаа жолооч нар өөрсдөө хариуцлагагүй сэтгэлгүй байна. Настай хүмүүс бид чинь хогны машин дээр хогоо ачиж чаддаггүй юм жолооч сэтгэл гаргаад ачаад өгүүл бид хөлс мөнгө өгдөг. Нэг сэтгэлтэй хүү байсан сүүлд ажиллаасай гарсан байсан. Тийм болохоор сэтгэл гаргаж ажиллаж байгаа хүмүүсээ яаж авч үлдэх үү цалин хөлсийн нэг шийдэж өгүүл зүгээр байх. Мэдээлэл өгч байгаа албан хаагчид жоохон чанга тодорхой ярьж баймаар байна.

А.Долгор-Өлзий (оролцогч): Машин дээр анхаарах цаг нь болсон зарим айлын хог нь багатахгүй 2,3 удаа ачих юм.

С.Дашдэмбэрэл (оролцогч): Хог үнэхээр хүндрэлтэй байна. Хогны асуудал зөвхөн ТҮК, төрийн ажил биш иргэдийг бүгдийн хамруулмаар байна. Соён гэгээрүүлэх ажил хиймээр байна. 2 хогийн цэгтэй байвал ямар вэ нэг талд нь шатдаг хогоо асгадаг нөгөө талд нь ангилдаг байвал. ТҮК-ийн ажиллагчид гэж нийгмийн баталгаа муу, техник хэрэгсэл үгүй хогноосоо гадна энэ хэдэн хүн нь сумын төвийн ногоон байгууламжийг хариуцдаг юм байна. ИТХ-аар хэлэлцээд энэ хэдийнхээ цалин хөлс, нийгмийн баталгаа дээр анхааруул зүгээр байх.

Д.Цэрэнтогтох (Сонсгол даргалагч): Санал хариулт авч дууслаа. Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон нийт оролцогчдодоо баярлалаа. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Баярлалаа.

Нийтийн сонсгол 14:25 цагт өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

Д.ЦЭРЭНТОГТОХ (ИТХ-ЫН
ТӨЛӨӨЛӨГЧ СОНСГОЛ
ДАРГАЛАГЧ)

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Г.СУГАР (ИТХ-ЫН ХЯНАЛТ
ШАЛГАЛТ, ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН)